



БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ  
БОЛОН МОБАЙЛ АППЛЕЙКЕШНИЙГ  
ХӨГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДАД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,  
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,  
http://www.nccd.gov.mn

2023-09-25 № 33/1479  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Үнийн санал ирүүлэх тухай

Тус төвөөс 2022 оноос эхлэн сүрьеэгийн эмчилгээнд цахим хяналтат эмчилгээг нэвтрүүлж, өвчтөнд ээлтэй, чирэгдэл багатай, амар хялбар, цаг хугацааг хэмнэсэн, эмээ ууж байгааг шууд хянах боломжтой мобайл апплейкешний хөгжүүлэлтийн ажил дуусаж, App Store, Play Store-д байршуулах шатанд явж байна.

Энэхүү апплейкешнийг үндэсний хэмжээнд сүрьеэгийн диспансераас гадна анхан шатны сум, өрхийн эрүүл мэндийн төв, томоохон төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хандаж буй сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлуудыг хурдан хугацаанд амар хялбар байдлаар бүртгэх, мэдээлэх, шинжилгээнд илгээх зорилготойгоор нэмэлт цонх, жагсаалт, тайлан гаргах, сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (tubis.nccd.gov.mn)-тэй мэдээлэл солилцох зэрэг хөгжүүлэлт, сайжруулалт хийх ажлыг гүйцэтгүүлэх гэж байгаа тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу үнийн саналыг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор [tender@nccd.gov.mn](mailto:tender@nccd.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ үү.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ **Х.БАЙГАЛМАА**



My document/2023 alban toot



Мобайл апплейкешний хөгжүүлэлт, сайжруулалт

Хийгдэх ажлууд	ДД	Дэд ажлууд
TUBIS APP	1.1	Хэрэглэгч нэвтрэх /email, утасны дугаараар баталгаажуулах/
	1.2	TUBIS APP дээр нэмэлт асуумжийн цонх үүсгэх /сэжигтэй тохиодол бүртгэх, батлагдсан тохиолдол бүртгэл, шинжилгээ илгээх /
	1.3	Илгээсэн жагсаалтууд харагдах
	1.4	Үр дүн харагдах, Тайлан эсвэл дашбоард
	1.5	Тест, нэвтрүүлэлт
TUBIS WEB / Зөвшөөрсөн Аж ахуй нэгж нэвтрэх/ sub domain	2.1	Хэрэглэгч нэвтрэх /email, утасны дугаараар баталгаажуулах/
	2.2	Иргэний мэдээллийг хураас шалган шинээр үүсгэх
	2.3	Сэжигтэй тохиолдол, батлагдсан тохиолдол, шижилгээг илгээх шинээр бүртгэх хэсэг
	2.4	Илгээсэн жагсаалтууд харагдах
	2.5	Үр дүн харагдах, Тайлан эсвэл дашбоард
	2.6	Тест, нэвтрүүлэлт
TUBIS Програмын <a href="https://tubis.nccd.gov.mn/">https://tubis.nccd.gov.mn/</a>	3.1	Хэрэглэгч үүсгэх /эмнэлэгээр/
	3.2	Tubis систем дээр дээрх 2 эх үүсгэвэрээр бүртгэгдсэн хүмүүсийн жагсаалтын цонх нэмэх
	3.3	Жагсаалтанд байгаа хүмүүсийг дуудах, шинжилгээнд илгээх, тохиолдол, хавьтал, урьдчилсан сэргийлэх эмчилгээний аль аль руу шилжүүлэх боломжтой байх. / оношилсон эмч нь бүртгэл хийж нэгж рүү шилжүүлдэг байх/
	3.4	Тест, нэвтрүүлэлт
Тайлан	4.1	Бүртгэсэн эмнэлгээр гарах
	4.2	Нэмэлт засвар, хөгжүүлэлт

Жич: Хийгдэх хөгжүүлэлт болон сайжруулалтын ажил 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дуусгасан байхыг шаардана.